

ХҮНСНИЙ НОГООНЫ ЭЭЛЖЛЭН ТАРИАЛАЛТ

Сэлгээ

Хүнсний ногооны таримлуудын сэлгээ нь эдийн засгийн болон агротехникийн үндэслэлтэй тухайн аж ахуйн нэгжид тохирсон цаг хугацаа, орон зайн нөхцөлд тохируулан таримлуудыг сэлгэн тариалж хөрсний үржил шимийг сайжруулах, ургац нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулахад оршино.

Сэлгээний давтамж

Сэлгээний давтамж нь жилээр илэрхийлэгдэх бөгөөд жил бүр тухайн талбайн таримлууд үндсээрээ өөрчлөгдөнө. Давтамжийн үргэлжлэх хугацаа нь сэлгэн тариалах тооноос хамаарна.

Сэлгээгүй талбайн хор хөнөөл

- Хүнсний ногооны таримлууд нь хөрснөөс өөрт тохирсон шим тэжээлийн бодисуудыг авч байдаг. Жишээ нь төмс калийг, лооль фосфорыг, байцаа азотыг гэх мэт. Иймд нэг талбайд нэг таримлыг сэлгэхгүй тариалахад хөрс нь тухайн бодисоор ядуурч байдаг.
- Хүнсний ногооны таримлууд нь өөр өөрийн өвчнөөр өвчилдөг. Эдгээр өвчнийг өдөөгч спорууд нь хөрсөнд хуримтлагдаж жил бүр өсөн нэмэгдэнэ.
- Өвчнөөс гадна хөнөөлт шавьж ихээхэн хор хөнөөлтэй. Жишээ нь шар лууванд луувангийн ялаа, сонгины тарималд сонгины ялаа гэх мэт хортон илэрч байдаг тул сэлгээ хэрэглээгүй талбайд үржиж байдаг.
- Сэлгээгүй талбайд хог ургамлын үр хуримтлагдан жил бүр ихэсдэг.
- Сэлгээгүй талбайд колин хуримтлагдан таримлын өсөлт хөгжлийг сааруулж ургац буурна.

Манай оронд зонхилон тариалдаг үндэс үрт таримал, бөөрөнхий цагаан байцаа, төмс зэрэг нь ихээхэн талбайг эзэлдэг хэдий ч өргөст хэмх, бөөрөнхий сонгино, лооль зэрэг таримлуудыг сэлгээнд оруулахын зэрэгцээ буурцагт таримал, улаан лууван, навчит үнэрт ногоог нэгтгэн нэг сэлгээ болгох боломжтой юм.

Хүнсний ногооны таримлуудыг 8, 6, 5, 4 сэлгээтэй талбайд тариална. Тухайн таримал нь 8, 6, 5, 4 жилийн дараа нэг талбайд эргэн таригдаж байдаг.

Зургаан сэлгээт талбайн тариалах бүдүүвч:

Implemented by

Мэдээллийн богц



1 дэх жилд
Навчит ногоо
Лооль
Хэмх
Сонгино, сармис
Үндэс үрт
Буурцагтан

2 дахь жилд
Үндэс үрт
Буурцагтан
Сонгино, сармис
Лооль
Хэмх
Навчит ногоо

3 дахь жилд
Хэмх
Навчит ногоо
Лооль
Буурцагтан
Сонгино, сармис
Үндэс үрт

4 дэх жилд
Сонгино, сармис
Үндэс үрт
Буурцагтан
Навчит ногоо
Лооль
Хэмх

5 дахь жилд
Лооль
Хэмх
Навчит ногоо
Үндэс үрт
Буурцагтан
Сонгино, сармис

6 дахь жилд
Буурцагтан
Сонгино, сармис
Үндэс үрт
Хэмх
Навчит ногоо
Лооль

Таван сэлгээт талбайн бүдүүвч:

1-р талбай		2-р талбай		3-р талбай		4-р талбай		5-р талбай			
Хэмх	4	Цэцэгт болон бөөрөнхий байцай	10	Төмс	10	Шар лууван	4	Лооль	9		
Хулуу	1					Яншуй	1			Чинжүү	1
Навчит ногоо	1					Сонгино	3				
Буурцагтан	2					Сармис	1				
Хүрэн манжин	2					Ногоон сонгино	1				

Мэдээллийн богц



1 дэх жил	1	2	3	4	5
2 дахь жил	5	1	2	3	4
3 дахь жил	4	5	1	2	3
4 дэх жил	3	4	5	1	2
5 дах жил	2	3	4	5	1

Дөрвөн сэлгээт талбайн ээлжлэн тариалалт:

а – 1 дэх жил

б – 2 дахь жил

в – 3 дахь жил

г – 4 дэх жил

- 1 - төмс, порей сонгино, яншуй;
- 2 - байцаа, бууцай;
- 3 - шош, вандуй, бөөрөнхий сонгино;
- 4 - шар лууван, шар манжин, хүрэн манжин.



Зураг 1: Дөрвөн сэлгээт талбайн ээлжлэн тариалалт (эх сурвалж: Ж.Байгалмаа)

Найман сэлгээт талбайн ээлжлэн тариалалт:

Хулуу	байцаа	Буурцаг-тан	Үндэс үрт	Сонгино	Гүзээлз-гэнэ	Гүзээлз-гэнэ	Хөх тариа
байцаа	Буурцаг-тан	Үндэс үрт	Сонгино	Гүзээлз-гэнэ	Гүзээлз-гэнэ	Хөх тариа	Хулуу
Буурцаг-тан	Үндэс үрт	Сонгино	Гүзээлз-гэнэ	Гүзээлз-гэнэ	Хөх тариа	Хулуу	байцаа
Үндэс үрт	Сонгино	Гүзээлз-гэнэ	Гүзээлз-гэнэ	Хөх тариа	Хулуу	байцаа	Буурцаг-тан
Сонгино	Гүзээлз-гэнэ	Гүзээлз-гэнэ	Хөх тариа	Хулуу	байцаа	Буурцаг-тан	Үндэс үрт
Гүзээлз-гэнэ	Гүзээлз-гэнэ	Хөх тариа	Хулуу	байцаа	Буурцаг-тан	Үндэс үрт	Сонгино
Гүзээлз-гэнэ	Хөх тариа	Хулуу	байцаа	Буурцаг-тан	Үндэс үрт	Сонгино	Гүзээлз-гэнэ
Хөх тариа	Хулуу	байцаа	Буурцаг-тан	Үндэс үрт	Сонгино	Гүзээлз-гэнэ	Гүзээлзгэнэ

Хүнсний ногооны тарималд сэлгэн тариалахаас гадна хамт өтгөрүүлэн тарихад хоорондоо зохицох, үл зохицох таримлууд гэж хуваагддаг.

Холимог тариалалтын давуу тал: Төрөл бүрийн таримлаас (гүнзгий ургадаг үндэс эсвэл үехэн ургадаг үндэс) хамаарч хөрсөнд үндэс сайн ургадаг ба хөрсний чийгийн хуваарьлалт сайн байдаг. Хөрсөн дэх шимт бодис нь тарималд илүү сайнаар хуваарьлагддаг. Зарим тарьмал хортон шавьжийг үргээдэг.

Хүснэгт 1: Холимог таримлын зохицох байдал

Хоорондоо зохицох тарималууд	Хоорондоо үл зохицох тарималууд
Цэс – шош	Цэс – лооль, чинжүү
Брокколи – хүрэн манжин	Вандуй – төмс, сонгино, сармис
Вандуй – цэс, хэмх, улаан лууван, шар лууван	Байцаа – лооль, шош
Байцаа – төмс, сонгино, хүрэн манжин, гоньд, яншуй	Сонгино, сармис – вандуй, шош
Цэцэгт байцаа – цоохор майлз	Шар лууван – гоньд, яншуй, цоохор майлз
Кольраби байцаа – сонгино, салат, хүрэн манжин, хэмх, үнэрт ногоо	Хэмх – төмс, үнэрт ногоо, хурган гуа
Эрдэнэ шиш – вандуй, төмс, хэмх, хулуу, шош	Чинжүү – хүрэн манжин
Сонгино, сармис – шар лууван, хүрэн манжин, цоохор майлз, лооль	Лооль – цэс, чинжүү, төмс, байцаа
	Хулуу – төмс
	Шош – сонгино, сармис, хүрэн манжин



Зураг 2: Холимог тариалалт (эх сурвалж: Ж.Байгалмаа)



Зураг 3: Хайрцган дахь тариалалт (эх сурвалж: David Hawgood, Wikimedia Common)

Хүснэгт 2: Өвчин болон хөнөөлт шавьжийн нэрвэгдэлтээс хамгаалсан ээлжлэн тариалах арга

Тухайн жилд тарьсан таримал	Дараагийн жилд тарих таримал	3-4 жилийн хугацаанд тарьж болохгүй таримал
Шар манжин, улаан лууван, сармаг манжин, байцаа	Хулууны овог, бурцагтан, сонгино, лооль, төмс	Шар манжин, байцаа, гоньд, хүрэн манжин, бууцай
Хэмх, хурган гуа, хулуу	Шар манжин, байцаа, сонгино, сармис, хүрэн манжин, лооль, төмс	Хэмх, хулуу, гоньд, салат
Шар лууван, гоньд, яншуй, цоохор майлз	Буурцагтан, сонгино, сармис, лооль, төмс	Гоньд, шар манжин, байцаа, хэмх, хулуу, хүрэн манжин, бууцай, салат
Сонгино, сармис	Шар манжин, байцаа, хэмх, хулуу, гоньд, буурцагтан, хүрэн манжин, лооль, төмс	Сонгино, сармис
Хүрэн манжин, бууцай	Хэмх, хулуу, буурцагтан, сонгино, сармис, салат, лооль, төмс	Шар манжин, байцаа, гоньд, хүрэн манжин, бууцай
Салат	Шар манжин, байцаа, хүрэн манжин, буурцагтан, сонгино, сармис, лооль, төмс	Хэмх, хулуу, гоньд
Лооль, төмс	Гоньд, шар манжин, байцаа, хэмх, хулуу, хүрэн манжин, буурцагтан, сонгино, сармис, салат	Лооль, төмс

ЗӨВЛӨМЖ

Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх үндсэн аргын нэг нь таримлыг сэлгэн тариалах явдал юм.

Таримлыг зөв сонгож сэлгэх нь ээлжлэн тариалах технологийг мөрдөх нөхцөлийг бүрдүүлдэг.

Сэлгээ нь таримлын өвчин хортноос урьдчилан сэргийлэх бөгөөд тарималд хөрсний үржил шимийг зөв зохистой ашиглах боломжийг бүрдүүлдэг.

Сэлгээг зөв баримтлахад хог ургамлын төрөл зүйл багасна.

Хөрсний үржил шим их байх тусам урьдавч таримал нь дараагийн тарималд хөнөөл бага учруулна. Урьдавч таримлыг түүний биологийн онцлогийг харгалзан сонгох шаардлагатай.

Эмхэтгэн боловсруулсан:	Герман-Монголын Хамтын Ажиллагааны „Тогтвортой Хөдөө Аж Ахуй“ Төсөл
Хаяг:	Засгийн газрын IXа байр, Энхтайвны өргөн чөлөө 16а, Улаанбаатар 13381, Монгол улс
Мэйл:	project.mn@iakleipzig.de
Вэб хуудас:	www.dmknl.de
Текст	УГТХ-ийн хүнсний ногоо судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Ж.Байгалмаа, мэйл хаяг: bbaigal70@gmail.com
Тайлбар	Энэхүү мэдээллийн богцонд багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.